БАТЛАВ:
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.БАЙГАЛЬ

ШТА1226 9023100942 9120513

ИРГЭДИЙГ ГАМШГИЙН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН КОНТЕНТ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ ИРГЭД ОЛОН НИЙТЭД ИЛ ТОД ШУУРХАЙ ХҮРГЭХЭД ШААРДАГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тендерийн нэр: Иргэдийг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн контент, авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд ил тод шуурхай хүргэх тухай.

Тендерийн дугаар: .
Техникийн шаардлагын тодорхойлолтод заасны дагуу нотлох баримтуудыг ирүүлнэ.
Видео шторк, мэдээ, рийл, зурагт постер хийж байсан туршлагатай байх. Хийгдэх ажилтай холбоотой нэг ижил төстэй ажил ирүүлнэ.

Дээрх төрлийн дүрслэлийг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвартай ажилтантай байна.

Үүнд: Дэлгэцийн урлагийн чиглэлээр дээд сургууль төгссөн мэргэжлийн боловсон хүчин заавал байх. Гэрээт зураглаач, сэтгүүлчтэй байж болно.

Компанийн дэлгэрэнгүй танилцуулга, мэдээ мэдээлэл, видео шторк, зурагт постер хийх үйлчилгээтэй холбоотой мэргэжлийн бүрэн тоног төхөөрөмжтэй байх.

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий мэдээлэл: Захиалагчийн хүсэлтийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд видео бичлэг хийх, фото зураг авах, цаг үеийн мэдээ, шторк, зурагт постер, видео эвлүүлэг, шууд дамжуулалтуудыг тус тус хийнэ. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хийж хэрэгжүүлж буй ажлууд, үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай сурталчлах зорилготой цаг үеийн мэдээ, видео шторк, рийл зэргийг FULL HD болон 4K өргөтгөлөөр мэргэжлийн түвшинд хийх. Фото зураг авалт хийж боловсруулах, Сэрэмжлүүлэг, Зөвлөмж, Мэдээ мэдээллийг зурагт постер хэлбэрээр тухайн сэдвийн хүрээнд ойлгомжтой байдлаар мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх.

Дүрслэл, дуу хоолой, хөгжим, зураг

Шторкууд нь дүрслэлийн хувьд FULL HD, 4K өргөтгөлтэй видео дүрс, time lapse, хөдөлгөөнт инфографик, 2D/3D график модель дүрслэл болон эдгээрийн хосолсон дүрслэлтэй байна.
Тодруулбал, тухайн сэдвийг харуулах хамгийн оновчтой дүрслэлийн (хосолмол байж болно) аргыг сонгоно.

Дуу хоолойн хувьд тухайн мэдээ, шторкын текстийг агуулгад нийцсэн хэв маягаар унших ба агуулга ойлгомжтой, сонсголонтой сонсогдохоор унших, ур чадвартай, мэргэжлийн хүний дуу хоолой байна.

Шторкод ашиглах хөгжим, дуу, ая болон дүрсүүд зохиогчийн эрхийн зөрчилгүй байх.

Ажил гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага:

Тухайн студи харьяалагдаж буй компани, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд:
59120 - Дуу, дүрсний бичлэг хийх,
59110 - Уран сайхны болон баримтат кино хийх үйл ажиллагааны чиглэл тус тус бүртгэгдсэн байх.
Мэргэжлийн бүрэн техник, тоног төхөөрөмжтэй байх
Үүнд:

Тоног төхөөрөмжийн нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1. Мэргэжлийн видео камер	ш	1
2. Мэргэжлийн фото аппарат	ш	1
3. Эвлүүлэг хийх өндөр үзүүлэлт бүхий суурин компьютер	ш	1
4. Дрон	ш	1
5. Микрофон	ш	4
6. DJI Pocket 3 Creater combo	ш	1
7. Бусад дагалдах техник хэрэгслүүд./Студийн лед гэрэл, камерийн хөл /tripod/ дүрс тогтворжуулагч /Ronin/	ш	-

Мэргэжлийн туршлагатай боловсон хүчинтэй байх

Телевизийн салбарт ажилласан мэргэжлийн туршлагатай боловсон хүчинтэй байх,
Гэрээт сэтгүүлч, зураглаачтай байж болно,
Мэргэжлийн ажилтны CV-г ирүүлэх, мэргэжлийн дипломын хуулбар хавсаргах
Ажилтан тус бүрийн CV-г ирүүлэх,
Ажлын цагаар тухайн гүйцэтгэх ажил дээрээ 1-2 хүнтэй баг байнга ажиллах,
/Амралтын өдрүүдэд шаардлагатай тохиолдолд 2 хүн ажиллах боломжтой байх/

Үргэлжлэх хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд.

№	Хийх ажлын нэр	Хугацаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	**Видео Шторк** Шторкууд нь HD, 4K видео дүрс, time lapse, хөдөлгөөнт инфографик, 2D/3D график модель дүрслэл болон эдгээрийн хосолсон дүрслэлийг ашигласан ойлгомжтой байдлаар хийгдсэн байна.	20-60 Секунд	ш	12
2.	**Зураг постер хийх** Сэрэмжлүүлэг, Зөвлөмж, Мэдээ мэдээллийг зураг постер хэлбэрээр тухайн сэдвийн хүрээнд	PNG JPEG RAW	ш	200

	ойлгомжтой байдлаар мэргэжлийн төвшинд хийж гүйцэтгэх.	148x210		
3.	**Цаг үеийн мэдээ** Тухайн мэдээ, мэдээллийг шаардлагад нийцүүлэн, яриа, текстэй түргэн шуурхай хийж гүйцэтгэх.	1-5 минут	ш	30
4.	**Шууд дамжуулалт /live/** Мэргэжлийн камераар хөдөлгөөнт байдлаар тухайн үйл явдал болж буй газар дээрээс нь дуу, дүрсний өндөр чанартайгаар шууд дамжуулалт гүйцэтгэх.	5-30 Минут	ш	5
5.	**Рийл** Мэргэжлийн камераар зураг авалтыг гүйцэтгэж дуу, дүрсний өндөр чанартайгаар шинэлэг эвлүүлэгтэй хийх.	60-90 секунд	ш	40
6.	**Фото зураг авалт хийх** Тухайн үйл явдлын хүрээнд мэргэжлийн фото зураг авалт хийж гүйцэтгэх, захиалагчид файлаар CD-нд хуулж өгөх	JPG RAW 210x297	ш	1000

БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН О.СОЛОНГОО